

1.1 Компанийн тухай

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 45 дугаар тогтоолоор “Уран болон бусад төрлийн цацраг идэвхт ашигт малтмалын геологи хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд дангаар болон бусад хуулийн этгээдтэй хамтран оролцох, төрийн төлөөллийг зохих хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх” чиг үүрэгтэй 100% төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр байгуулагдсан.

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор “Мон-Атом” ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг бүхэд нь “Эрдэнэс Монгол” ХХК-нд шилжүүлж охин компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна.


Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3-т цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн нийт хувьцааны 34, 51 доошгүй хувийг төр үнэ, төлбөргүй эзэмшихээр заасан.

1.1.1. Бүтэц

“Мон-Атом” ХХК-ийн “Хувьцаа эзэмшигчдийн хурал” буюу “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 02 тоот тогтоолоор тус компанийн бүтэц, зохион байгуулалтыг Гүйцэтгэх болон Дэд захирал, 2 албатай нийт 12 ажилтны орон тоотой байхаар баталсан.

2018 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар тус компанийн орон тоог нэгээр нэмэгдүүлсэн.

Компани нь 2021 оны байдлаар дээр дурдсан тогтоолоор батлагдсан бүтэц, зохион байгуулалт, орон тоогоор үйл ажиллагаагаа явуулж байна.



1.2.1. Үндсэн үйл ажиллагаа

Тус компанийг “Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого”-ын дагуу Монгол Улсын Засгийн

газрын 2009 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 45 дугаар тогтоолоор “Уран болон бусад төрлийн цацраг идэвхт ашигт малтмалын геологи хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд дангаар болон бусад хуулийн этгээдтэй хамтран оролцох, төрийн төлөөллийг зохих хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх” стратегийн ач холбогдол бүхий орд газруудад төрийг төлөөлж ажиллах чиг үүрэгтэй төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсан.

Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогын хүрээнд цацраг идэвхт ашигт малтмалын нөөц баялгийг өсгөн нэмэгдүүлэх, түүнийг энхийн зорилгоор олборлогч, боловсруулагч, экспортлогч улмаар тэргүүлэгч орны нэг болох, нөлөө бүхий улсуудын стратегийн сонирхлыг буй болгох, Монгол Улсын тогтвортой хөгжил, үндэсний аюулгүй байдлыг хангах зорилготой.

Хууль эрх зүйн орчин

Монгол Улсын Их хурлын 2009 оны 45 дугаар тогтоолоор Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого болон Цөмийн энергийн тухай хуулийг баталснаар салбарын эрх зүйн орчин бүрдсэн.

Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлогын зорилт нь цацраг идэвхт ашигт малтмалын нөөц баялгаа гүнзгийрүүлэн судлах, түүнийг энхийн зорилгоор олборлогч, боловсруулагч, экспортлогч улмаар тэргүүлэгч орны нэг болох, улс орныхоо стратегийн ач холбогдлыг нэмэгдүүлэх, нөлөө бүхий улсуудын стратегийн сонирхлыг буй болгох, Монгол Улсын тогтвортой хөгжил, үндэсний аюулгүй байдлыг дээшлүүлэхээр тусгагдсан болно.

Монгол Улс нь цацраг идэвхт ашигт малтмал олборлох, боловсруулах, баяжуулах, үйлдвэр байгуулах бодлогыг хэрэгжүүлэхдээ ордыг дагалдагч ашигт малтмалын хамт цогц байдлаар ашиглах, бүтээгдэхүүнийг олон улсын жишигт нийцсэн мэргэжлийн хяналт доор экспортлох бодлого баримтална.

Монгол Улсын төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн салбарт баримтлах бодлогын хүрээнд дор дурдсан холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгон ажиллаж байна. Үүнд:

- Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого;
- Олон улсын нэгдэн орсон конвенц, гэрээ, хэлэлцээр;
- Цөмийн энергийн тухай хууль;
- Ашигт малтмалын тухай хууль;
- Компанийн тухай хууль;
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль;
- Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль;
- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал;

- Бусад хууль тогтоомж.

Компани нь өөрийн дүрэмд заасны дагуу дараах үндсэн үйл ажиллагааг эрхэлнэ.
Үүнд:

- Монгол Улсын нутаг дэвсгэрт уран болон бусад төрлийн цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн геологийн судалгаа, хайгуул хийх, нөөцийг өсгөн нэмэгдүүлэх,
 - Цацраг идэвхт ашигт малтмалын хүдрийг олборлох, боловсруулах, дэлхийн зах зээлд нийлүүлэх,
 - Монгол Улсын хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлогын дагуу цөмийн эрчим хүч ашиглах хүчин чадлыг бий болгох санал, үндэслэл боловсруулж, хэрэгжилтийг хангах,
 - Атомын цахилгаан станцад хэрэглэгдэх цөмийн түлшний циклийн зөвшөөрөгдсөн шат дамжлагыг бий болгон хөгжүүлэх,
 - Уран болон бусад төрлийн цацраг идэвхт ашигт малтмалтай холбоотой гадаад улсын ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг компани болон бусад бүх төрлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх,
 - Эдийн засгийн үр ашигтай, хүн ард, байгаль орчинд сөрөг нөлөөгүй дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, аюулгүй байдлыг хангаж ажиллах,
 - Уран, цөмийн эрчим хүчний судалгаа, шинжилгээ эрхэлж үндэсний боловсон хүчин бэлтгэх, сургах.
- Бусад